



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/158

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, чанар, хүртээмжтэй хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан Нутгийн захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Жаргалант сумын Бугат багийн нийгмийн ажилтан Сүрэнгийн Сарантуяа, авто тээврийн постын ахлах тээвэр бүртгэгч Хүтүүгийн Батхүү нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан С.Сарантуяа, Х.Батхүү нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ